



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 07 дугаар
сврын 19-ны өдөр

Дугаар ХЭГ
1610

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011


УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ГАНБОЛД ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилт, явц байдлын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар бэлтгүүлэн үүгээр хүргүүлж байна.

Хавсралт: 11 хуудас.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 07 дугаар
сарын 19 ны өдөр

Дугаар ХЭГ
1610

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011


УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
М.БИЛЭГТ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилт, явц байдлын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар бэлтгүүлэн үүгээр хүргүүлж байна.

Хавсралт: 11 хуудас.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 07 дугаар
сарын 19-ны өдөр

Дугаар ХЭГ
1610

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011


УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилт, явц байдлын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар бэлтгүүлэн үүгээр хүргүүлж байна.

Хавсралт: 11 хуудас.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Л.ЭНХ-АМГАЛАН, Д.ГАНБОЛД,
М.БИЛЭГТ НАРААС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД
ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Асуулга 1. *Эмнэлгийн тусламж, үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй хүргэх, чанар, хүртээмжийг дээшлүүлэх, эмнэлгийн ачааллыг бууруулах боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн дээрх хуулийн дагуу гаргаж мөрдөх журмуудыг хэрхэн боловсруулж, хуулийн заалтууд хэзээ бүрэн хэрэгжих нөхцөл бүрдэх талаар:*

Хариулт. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан бөгөөд тус хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шинээр болон шинэчлэн боловсруулах дүрэм, журам, стандарт, холбогдох бусад шийдвэрүүдийн жагсаалтыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар баталсан байна. Уг тушаалд шинээр болон шинэчлэн боловсруулах 20 журам, заавар, жагсаалт болон 1 багц стандарт /нийт 13 стандарт/ тусгагдсан. Үүнээс 2018 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 6 журам батлагдаж хэрэгжиж байгаа ба 9 журмын төслийн боловсруулалт 70-80%, 3 журмын төсөл 30%-тай байна.

Эрүүл мэндийн тухай болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар нэгтгэн 1 багц буюу 13 стандарт боловсруулж батлахаас 8 стандарт батлагдсан, 3 стандартын төслийг боловсруулж, Стандартчилал, хэмжил зүйн газрын Эрүүл мэндийн техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж, төслийг Стандарчлалын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. *Шинээр болон шинэчлэн боловсруулах дүрэм, журам, стандарт, бусад шийдвэрүүдийн хэрэгжилт, явцыг талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав. Хавсралт 1-ээс үзнэ үү.*

Асуулга 2. *Иргэд цаг алдалгүйгээр өвчний эрт илрүүлгийн оношлогоо, эмчилгээ хийлгэж чадаагүйн улмаас өвчин нь хүндэрч, улмаар гадаад оронд очиж оношлуулах, эмчилгээ хийлгэхээр ихээхэн зардал, чирэгдэл учирч хувь хүний болоод улс орны эдийн засагт хүндрэл учруулж байна. Иргэдэд учирч байгаа энэ хүндрэл бэрхшээлийг бууруулах талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар:*

Хариулт. Дараах ажил, арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:

а) Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар:

Эрүүл мэндийн даатгалын орлого, зарлагын зөрүү багассан нь 2015 онд Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний багц нэмэгдэж, зарцуулалтын хэмжээ өссөнтэй холбоотой юм. Тухайлбал, эрүүл мэндийн даатгалын сангаас "өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх протезийн тодорхой хувь"-ийг, "Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр, төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг батлан 184 ерөнхий нэршлийн 822 худалдааны нэрийн эмэнд 40-80 хувийн хөнгөлөлт"-ийг, "Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан "Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөрийн хүрээнд элэгний "С" вирусыг илрүүлэх оношилгоо, шинжилгээ болон эмийн үнийн хөнгөлөлт"-ийг тус тус санхүүжүүлж байна. Мөн 2017 оны "Томуу, томуу төст өвчлөлөөр өвчилсөн 5 хүртэлх насны хүүхдийн ууж

хэрэглэх эмийн үнэд хөнгөлөлт үзүүлэх тухай” 01 дүгээр тогтоолын дагуу 124,0 мянган хүүхдэд 1,0 тэрбум төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлтийн зардлыг олгосон.

2018 оноос Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-д заасны дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж эхэлсэн. Энэ онд даатгалын байгууллага нь эрүүл мэндийн даатгалын цахим системийг шинэчлэх, мэдээллийн технологийг сайжруулж, эрүүл мэндийн даатгалын цахим системийг 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс шинэчлэн цахим системийг өрхийн эмнэлэг, эмийн сангуудад нэвтрүүлэх, цаашид програм хөгжүүлэлтийг тасралтгүй хийж, уг системийг бүрэн нэвтрүүлэн ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.12-т магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцахаар нэмэлт, өөрчлөлт оруулж, 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх болсон бөгөөд үйл ажиллагаа явуулж байгаа спортын клубыг магадлан итгэмжлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагааг явуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

2018 оны эхний хагас жилд эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтийг давхардсан тоогоор 3,454,038 хүнд үзүүлж, нийт 150,880,085,977 төгрөг зарцуулсан. Үүнээс 22,341 хүнд /3,364,839,107 төгрөг/ сувиллын тусламж, үйлчилгээ, 511,710 хүнд зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт, 32,126 хүнд /6,853,222,663 төгрөг/ элэгний “В”, “С” вирусийн эсрэг эмийн үнийн хөнгөлөлт, 30,860 хүнд /2,484,300,000 төгрөг/, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээний зардалд 1,937 хүн /196,050,000 төгрөг/, элэгний “В”, “С” вирусийг илрүүлэх, баталгаажуулах шинжилгээнд 6,499 хүн /1,046,384,440 төгрөг/-ийг хамруулаад байна.

b) Хавдар судлалын үндэсний төв, эрүүл мэндийн байгууллагын хувьд хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар:

Хавдар судлалын үндэсний төв 2012 оноос “Хөх, умайн хүзүүний өмөнгийн илрүүлэг, эргэн дуудах тогтолцоо”-г үндэсний хэмжээнд анх нэвтрүүлсэн бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2012 оны “Эргэн дуудах тогтолцооны бүртгэлийн удирдамж” болон “Умайн хүзүү, хөх өмөнгийн эмнэлзүйн удирдамж”-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх удирдамжийн дагуу 2012 оноос хойш умайн хүзүүний хорт хавдар, хөхний хавдрын эрт илрүүлэг үзлэг хийгдэж эхэлсэн бөгөөд өнөөдрийг хүртэл нийт 462,946 эмэгтэй умайн хүзүү, хөхний хорт хавдарын эрт илрүүлэг үзлэгт хамрагдаж, 461 тохиолдлын хорт хавдрын өвчлөлийг илрүүлсэн. /Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний статистик үзүүлэлтийг хавсаргав. Хавсралт 2-оос үзнэ үү./

2018 оны эхний 5 сарын байдлаар хөхний хавдрын эрт илрүүлэгт 155,549 эмэгтэй хамрагдсан байна. Хөхний эмнэлзүйн шинжилгээгээр эерэг гарсан эмэгтэйчүүдийн тоо 683, хорт хавдарын 6 тохиолдол илэрсэн. Умайн хүзүүний хорт хавдарын эрт илрүүлэгт зорилтот насны 38,232 эмэгтэй хамрагдсан бөгөөд хамралтын хувь 16,9%-тай байна. Хорт хавдар оношлогдсон 17 тохиолдол гарсан.

Мөн эрт илрүүлэг үзлэгийн талаар дараах арга хэмжээг авч ажиллаж байна:

- хүн амын эрүүл мэндийн боловсрол олгох эрт илрүүлэг, үзлэг шинжилгээний ач холбогдлын талаар мэдлэг олгох сургалтыг 11,834 хүнд зохион байгуулж, мэдээлэл, сургалт, сурталчилгааны 6 төрлийн инфографик боловсруулан цахим санд байршуулан олны хүртээл болгосон. 7,000 гаруй гарын авлага, нугалбар хэвлүүлэн тараасан байна;

- Мөн 2011 оноос хойш Эрүүл мэндийн яам, Хавдар судлалын үндэсний төвөөс санаачлан ХААН банк, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизтэй хамтран “Хавдрын эсрэг үндэсний аян”-ыг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг. Аянд эрсдэл бүлгийн 30,991 хүний үзлэгт хамруулсан бөгөөд хавдрын урьдал оноштой 8,916 тохиолдол, хортой хавдартай 550 тохиолдлыг илрүүлсэн бөгөөд эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон мэс ажилбарыг орон нутагт хийж тусламж үзүүлсэн /Хавдрын эсрэг үндэсний аяны тайланг хавсаргав. Хавсралт 3-аас үзнэ үү./ Тус аяны хүрээнд дан ганц эрт илрүүлгийн тусламж үйлчилгээгээр зогсохгүй хүн амд эрүүл амьдралын дадал төлөвшүүлэх, халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлс, тэдгээрээс сэргийлэх, эрт илрүүлэлтийн ач тусын талаар ухуулан таниулах, эрсдэлт бүлгийн хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, орон нутгийн эмч, мэргэжилтнийг хорт хавдрын эрт илрүүлэлт, хавдрын оношилгоо, эмчилгээний чиглэлээр сургах, эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн бэлтгэх, чадавхжуулах сургалт зохион байгуулах зэрэг ажлууд хийж гүйцэтгэсэн байна.

Цаашид Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоолоор батлагдсан “Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хүн амын хорт хавдраас сэргийлэх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдахын ач холбогдлын талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлуудыг тогтмол хийх болно.

Мөн хорт хавдарын тусламж, үйлчилгээг аймаг, дүүргийн түвшинд бэхжүүлэх, тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах арга хэмжээ авч ажиллаж байгаагийн зэрэгцээ хорт хавдарын тусламж, үйлчилгээнд орчин үеийн шинэ арга, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлыг шат дараатайгаар нэвтрүүлэх ажлыг дээрх хөтөлбөрийн хүрээнд хийж байна.

Асуулга 3. *Иргэд эмнэлгийн байгууллага, эмчээ өөрөө сонгож үйлчлүүлэх нөхцөлийг бий болгоход чиглүүлж хийж байгаа ажлууд, үр дүнгийн талаар:*

Хариулт. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор 2017-2018 онд “Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм”, “Өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах журам”, “Өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт”, “Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээний загвар, гэрээ дүгнэх заавар”, “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шалтгааны улмаас нийслэлд шилжин амьдрах шаардлагатайг нотлох эмнэлгийн тодорхойлолт олгох түр журам”, “Зайлшгүй шалтгааны улмаас хөдөө орон нутгаас нийслэлд оршин суух тодорхойлолт гаргах жагсаалт”, “Эмнэлгийн тодорхойлолт гаргах маягт”, “Шатлал хооронд өвчтөн шилжүүлэх журам”-ыг тус тус батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт”, “Иргэн өрх, сум, тосгоны эмчээ сонгон бүртгүүлэх” журмын төслийг тус тус боловсруулж байна.

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХОЛБОГДУУЛАН ШИНЭЭР БОЛОН ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ ДҮРЭМ, ЖУРАМ, СТАНДАРТ, ХОЛБОГДОХ БУСАД ШИЙДВЭРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ

2018.07.05-ны байдлаар

№	Эрх бүхий байгууллага	Хуулийн заалт	Хэрэгжилт, хувиар	Тайлбар, санал
1	ЗАСГИЙН ГАЗАР	21.6.Хувийн төрөлжсөн эмнэлэг, клиник, түргэн төвөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх энэ хуулийн 18.1-д заасан улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний сонгон шалгаруулах болон гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж батлах тухай" А/138 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийн хурлын бэлтгэл ажлыг хангах хүрээнд улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлдэг тусламж, үйлчилгээний жагсаалтыг боловсруулж хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын төлөөллийн дунд хэлэлцүүлэг хийхээр ажиллаж байна. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21.1-д "... тус хуулийн 18.1, 18.2-т заасан тусламж, үйлчилгээний санхүүжилтийн хэмжээг тогтооход тухайн тусламж, үйлчилгээний удирдамж, стандартад суурилсан норматив өртгийн тооцоонд үндэслэсэн жишгийг мөрдөнө" гэж заасан байдаг. Хуулийн 18.1 болон 18.2-т заасан тусламж, үйлчилгээний өртгийн судалгааг Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр хийлгэхээр Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон шалгарсан судалгааны байгууллагатай хамтран бэлтгэл ажлыг хангаж байна. Гэрээний дагуу урьдчилсан санхүүжилт авч гүйцэтгэх журам, гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг бодит өртгийн тооцоо, судалгааг хийгдсэний дараа боловсруулах болно. Хэрэгжилт: 70%	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, клиник, түргэн тусламжийн төвийн үйлчилгээний жагсаалт батлаг-даагүй тул хүлээгдэж байна. Жагсаалтад эрүүл мэндийн байгууллагаас санал авч нэгтгэж байгаа (ЭТГ)
	ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ЗГ-ЫН ГИШҮҮН	5.4 Өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/05 дугаар тушаалаар "Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээний загвар" батлагдан гарсан. Тушаалын нэгдүгээр хавсралтаар "Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хийх гурвалсан гэрээний загвар", хоёрдугаар хавсралтаар "Гэрээ дүгнэх журам", гуравдугаар хавсралтаар "Гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлтийг" тус тус боловсруулан батлуулсан. Тус тушаалаар гэрээг байгуулах, гэрээг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох тухай эрхийг Эрүүл мэндийн газар болон Засаг даргын тамгын газарт олгосон. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/367 дугаар тушаалаар "Өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах журам"-ыг батлуулсан. 100%	
		6.2.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журам	Эрүүл мэндийн сайдын 2017 оны 129 дүгээр тушаалаар "Өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлах тухай" баталсан. Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартыг шинэчлэх, шинээр боловсруулах ажлыг Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/182 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг дараах стандартуудыг боловсруулан, Стандарт, хэмжил зүйн газрын Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 34 дүгээр тогтоолоор "Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны	

		<p>стандарт MNS 5292:2017" батлагдсан. Хэрэгжилт: 100%</p> <p>Сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтыг боловсруулан холбогдох байгууллагуудаас санал авч байна. Тус журам сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэлийг шинэчлэх ажилтай холбоотойгоор хойшилсон. Бодлого төлөвлөлтийн газар сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэлийг шинэчлэхээр ажлыг хэсэг байгуулан, ажиллаж байна.</p> <p>Хэрэгжилт: 30%</p>
4	7.3.Иргэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчээ сонгон бүртгүүлэхтэй холбогдох	<p>Иргэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчээ сонгон бүртгүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулах журмыг боловсруулах Ажлын хэсэг байгуулан, журмын төслийг боловсруулаад байна.</p> <p>Хэрэгжилт: 30%</p>
5	7.6.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс иргэнийг эмнэлгийн лавлагаа, шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт илгээх	<p>Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/120 дугаар тушаалаар "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шалтгааны улмаас нийслэлд шилжин амьдрах шаардлагатайг нотлох эмнэлгийн тодорхойлолт олгох тур журам", "Зайлшгүй шалтгааны улмаас хөдөө орон нутгаас нийслэлд оршин суух тодорхойлолт гаргах жагсаалт", "Эмнэлгийн тодорхойлолт гаргах маяг"-ыг баталсан.</p> <p>Иргэнийг эмнэлгийн лавлагаа, шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт илгээхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/235 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулж, Эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх журмын төслийг боловсруулсан. Цахим програм хангамж хийхтэй холбоотой 2018 оны III улиралд батлуулахаар түр хойшуулаад байна. Хэрэгжилт: 70%</p>
6	8.3.Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын тусламж, үйлчилгээний жагсаалт, журам	<p>Мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага болох 21 аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллага, Төв, эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдээс одоо үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний жагсаалтын судалгааг авч, тусламж, үйлчилгээний өртөг зардлыг тооцох, суурь тусламж, үйлчилгээний нэр төрөл жагсаалтыг боловсруулахаар Олон улсын өвчний 10 дугаар ангилалын оношийн бүлгийн дагуу бүлэглэхэд Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлүүдээс санал авч нэгтгэн эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын бүлэглэсэн жагсаалтын дагуу боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулахаар газар хэлтсээр тойруулж, санал авч байна. Хэрэгжилт: 70 %</p>
7	9.4. Эх барихын тусламж, үйлчилгээнд мөрдөх заавар, үр хөндөх, жирэмслэлтийг таслах ажилбар гүйцэтгэх журам	<p>Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/102 дугаар тушаалаар "Нярайн сурфактант эмчилгээний заавар", "Заавар батлах тухай" А/297 дугаар тушаалаар "Нярайн амьсгал хямралын хамшинжийн оношилгоо, эмчилгээний заавар", "Амьсгалын замд үргэлжилсэн эерэг даралт үүсгэн амьсгалуулах эмчилгээний заавар", "Төрөх үед болон төрсний дараа нярайд үзүүлэх тусламжийн заавар", "Нярайн сэхээн амьдруулалтын заавар", "Дутуу, бага жинтэй нярайг амаар хооллох заавар" зэрэг Эх</p>

	барих тусламж, үйлчилгээний заавар, А/398 дугаар тушаалаар "Үр хөндөх, жирэмслэлтийг таслах ажилбар гүйцэтгэх журам"-ыг тус тус батлуулсан. Хэрэгжилт: 100 %		
8	<p>10.3.Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх үйлчлүүлэгчийг эрэмбэлэх болон яаралтай тусламжийг зохион байгуулахтай холбогдох заавар, журам, маягт</p> <p>Эрүүл мэндийн сайдын тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсэг Түргэн тусламжийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартын төслийг боловсруулж нэгдсэн ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн саналыг тусган боловсруулсан. Эрүүл мэндийн яамны дэргэдэх яаралтай тусламжийн мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран Түргэн тусламжийн болон эмнэлгийн яаралтай тусламжийн маягт тус бүрд нь хүүхэд, насанд хүрэгсдийн гэсэн ангиллаар шинэчлэн боловсруулсан. "Хүүхдийн яаралтай тусламжийн заавар" болон "Гэмтэл ослын яаралтай тусламжийн заавар" тус тус боловсруулсан. Хэрэгжилт: 70 %</p>	10.3.Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх эрэмбэлэх болон яаралтай тусламжийг зохион байгуулахтай холбогдох заавар, журам, маягт	
9	<p>11.3.Түргэн тусламжийн үйлчилгээний зохион байгуулалт, үйлчлэх хүрээ</p> <p>Түргэн тусламжийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартын төсөл боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/282 дугаар тушаалын хавсралтаар батлуулан ажиллуулж байна. Түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх, түргэн тусламжийн машинд байх эм, багаж хэрэгслийн жагсаалт, түргэн тусламжийн таних тэмдэг, ажилтнуудын хувцаслалтыг зохицуулсан журмын төслийг боловсруулж Эрүүл мэндийн яамны дэргэдэх яаралтай тусламжийн мэргэжлийн зөвлөлийн саналыг авч нэгтгэн "Түргэн тусламжийн төвийн стандарт"-ын төслийг боловсруулж Стандарт, хэмжилзүйн газарт хүргүүлсэн. Хэрэгжилт: 80%</p>	11.3.Түргэн тусламжийн үйлчилгээний зохион байгуулалт, үйлчлэх хүрээ	
10	<p>12.5.Сувилахуйн болон хөнгөвчлөх, асаргаа үзүүлэх, сувилгааны төвийг байгуулах журам, үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, сувилахуйн төв, хөнгөвчлөх, асаргаа, сувилгааны төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалт</p> <p>Сувилахуйн төвийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм, Сувилахуйн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, Сувилахуйн төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалтыг батлуулахаар Эрүүл мэндийн сайдын тушаалын төсөл боловсруулж, газар хэлтсээс тойруулан санал авч, Эрүүл мэндийн байгууллагуудад албан тоотоор хүргүүлж саналыг нэгтгэсэн. Сувилахуйн болон хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төвийн үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, сувилахуйн төв, хөнгөвчлөх, асаргаа, сувилгааны төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалт Эрүүл мэндийн сайдын 2017 оны 381, 2016 оны 329 дүгээр тушаалаар тус тус батлагдсан. Хэрэгжилт: 100%</p>	12.5.Сувилахуйн болон хөнгөвчлөх, асаргаа үзүүлэх, сувилгааны төвийг байгуулах журам, үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, сувилахуйн төв, хөнгөвчлөх, асаргаа, сувилгааны төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалт	
11	<p>13.5.Сэргээн засах төв, сувилал байгуулах, үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журам болон сувилал, сэргээн засах төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалт</p> <p>Сэргээн засах төв, сувилал байгуулах, үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журам болон сувилал, сэргээн засах төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалтыг боловсруулах ажлын хэсэг байгуулан Хэрэгжилт: 80%</p>	13.5.Сэргээн засах төв, сувилал байгуулах, үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журам болон сувилал, сэргээн засах төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалт	

12	15.29.Нэр дэвшүүлэн сонгох хурлыг зохион байгуулах журам	"Журам батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/189, А/209 тоот тушаалаар төрийн болон орон нутгийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн ТУЗ-д ажиллах олон нийтийн төлөөллийг сонгох журмыг батлуулсан. Хэрэгжилт: 100%	Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 сарын 05-ны өдрийн А/382 тоот тушаалаар Улсын гуравдугаар төв эмнэлэг, А/384 тоот тушаалаар АӨСҮТ-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг тус тус батламжилсан.
13	16.2.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг сонгон шалгаруулах	Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг сонгон шалгаруулах журмын төсөлд харьяа нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэшлийн төвүүдээс саналыг нэгтгэн боловсруулж, тушаалыг батлуулахаар удирдлагад танилцуулан, 2018 оны 11 дүгээр сард батлуулахаар төлөвлөж байна. Хэрэгжилт: 80%	
14	22.3.Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журам	Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журмын төслийг боловсруулан, 2018 оны III улиралд батлуулахаар төлөвлөж байна. Хэрэгжилт: 70%	
15	21.2.Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн болон тусгай эмнэлэг, амаржих газар, клиник нь энэ хуулийн 18.1, 18.2-т заасан тусламж, үйлчилгээг гэрээний дагуу урьдчилсан санхүүжилт авч гүйцэтгэх бөгөөд санхүүжилт авах журам, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур	"Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А/138 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийн хурлын бэлтгэл ажлыг хангах хүрээнд улсын төсөв болон Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлдэг тусламж, үйлчилгээний жагсаалтыг боловсруулж хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын төлөөллийн дунд хэлэлцүүлэг хийхээр ажиллаж байна. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21.1-д "... тус хуулийн 18.1, 18.2-т заасан тусламж, үйлчилгээний санхүүжилтийн хэмжээг тогтооход тухайн тусламж, үйлчилгээний удирдамж, стандартад суурилсан норматив өртгийн тооцонд үндэслэсэн жишгийг мөрдөнө" гэж заасан байдаг. Иймд 21.2-т тусламж, үйлчилгээг гэрээний дагуу урьдчилсан санхүүжилт авч гүйцэтгэх журам, гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг бодит өртгийн тооцоо, судалгааг хийгдсэний дараа боловсруулна. Хуулийн 18.1 болон 18.2-т заасан тусламж, үйлчилгээний өртгийн судалгааг Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр хийлгэхээр Сангийн яам, ХНХЯ болон шалгарсан судалгааны байгууллагатай хамтран бэлтгэл ажлыг хангаж байна. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21.1-д "... тус хуулийн 18.1, 18.2-т заасан тусламж, үйлчилгээний санхүүжилтийн хэмжээг тогтооход тухайн тусламж, үйлчилгээний удирдамж, стандартад суурилсан норматив өртгийн тооцоонд үндэслэсэн жишгийг мөрдөнө" гэж заасан тул 21.2-т тусламж, үйлчилгээг гэрээний дагуу урьдчилсан санхүүжилт авч гүйцэтгэх журам, гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг бодит өртгийн тооцоо, судалгааг хийгдсэний дараа боловсруулна. Хуулийн 18.1 болон 18.2-т заасан тусламж, үйлчилгээний өртгийн судалгааг Шинжлэх ухаан, технологийн	ШУТ-ийн сангаас хэрэгжүүлэх "Төр хариуцах тусламж, үйлчилгээний өртөгийг тооцох" төслийн ажлыг эрчимжүүлэх Түр журам боловсруулах-журам батлагдаж хэрэгжитэл ямар эх зүйн актыг баримтлах талаар

			сангийн санхүүжилтээр хийлгэхээр Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон шалгарсан судалгааны байгууллагатай хамтран бэлтгэл ажлыг хангаж байна. Шинжлэх ухаан, технологийн сангаас хэрэгжүүлэх "Төр хариуцах тусламж, үйлчилгээний өртөгийг тооцох" төслийн хүрээнд хийгдэхээр хүлээгдэж байна. Хэрэгжилт: 70%	“Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 264/А/293 тоот тушаалаар “Нэмэлт тусламж, үйлчилгээний төлбөрийг иргэнээс төлүүлэх журам” батлагдсан
4	СТАНДАРТ ЧИЛЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСА Н ТӨРИЙН ЗАХИРГАА НЫ БАЙГУУЛЛА ГАТАЙ ХАМТРАН БАТЛАХ	16	21.4.Энэ хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасан төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу нэмэлтээр үзүүлж болох бөгөөд нэмэлт үйлчилгээний төлбөрийг иргэнээс төлүүлэхтэй холбогдох журам	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 264/А/293 дугаар тушаалаар “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” тушаалыг батлуулсан. Тушаалын хавсралтаар “Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ”, “Төрийн болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам”, “Нэмэлт тусламж, үйлчилгээний төлбөрийг иргэнээс төлүүлэх журам” тус тус батлагдсан. Захиргааны ерөнхий хуулийн дагуу тус хамтарсан тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3781 дугаарт бүртгүүлсэн. Хэрэгжилт: 100%
		17	14.4.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх барилга байгууламж, техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, эм, эмнэлгийн хэрэгсэл болон хүний нөөцөд тавих шаардлага	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг ӨЭМТ, ЦССҮТ, ЗӨСҮТ, ЭСҮТ, Клиникийн бүтэц үйл ажиллагааны стандартыг батлуулсан. Сувилахуйн төв, Хөнгөвчлөх асаргаа сувилгааны төв, Түргэн тусламжин төв, Сэргээн засах төвийн бүтэц үйл ажиллагааны стандартыг шинээр боловсруулаад байна. Хэрэгжилт: 100%
		18	12.6.Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар зохицуулна.	Сувилахуйн төвийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм,сувилахуйн төвд үзүүлэх тусламж үйлчилгээний жагсаалт, сувилахуйн төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалт Эрүүл мэндийн сайдын А/381 дүгээр тушаалаар батлагдсан. Хэрэгжилт: 100%
		19	13.6.Сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур	Сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн төсөл боловруулж байна. Хэрэгжилт: 30%

	20	<p>үзүүлэлтийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар зохицуулна.</p> <p>15.22. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний урамшууллын жишиг хэмжээ, олгох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.</p>	<p>"Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах журам"-ыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/149 дүгээр тушаалаар батлуулсан. Мөн "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийн төлөөллийг сонгох журам"-ыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/189 дүгээр тушаалаар батлуулж, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/209 дүгээр тушаалаар сонгон шалгаруулах хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж гарах журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд тус хуулийн 16.5-д заасан нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд олгох "урамшуулал"-ыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан тул тус хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт дагалдан хойшлогдож байгаа болно.</p>	<p>Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд "2 дугаар зүйл. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.21 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн "урамшуулал", 15.22 дахь хэсгийн "урамшууллын жишиг" гэснийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө." гэж заасан тул хойшлогдож байгаа болно.</p>
--	----	---	---	--

**Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний статистик
үзүүлэлт 2011-2017 он**

/Эх сурвалж: ХСҮТ-ийн тандалт, судалгааны нэгж/

№	Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
1.	Умайн хүзүүний өмөнгийн илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн тоо (30-60 насны эмэгтэй)	162520	136988	164871	187684	164017	226571
2.	Умайн хүзүүний өмөнгийн илрүүлэг үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо	75046	65810	71636	79125	78708	92621
3.	Умайн хүзүүний өмөнгийн илрүүлэг үзлэгт зорилтот насны бүлгийн хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо (30-60 насны эмэгтэй)	67565	58857	65625	72236	73706	84716
4.	Зорилтот насны бүлгийн эмэгтэйчүүдийн илрүүлэг үзлэгт хамрагдсан хувь	41,6	43,0	32,6	38,8	44,9	37,4
5.	Илрүүлэг үзлэгээр илэрсэн өмөнгийн тоо	39	118	103	78	68	55

Хавдрын эсрэг үндэсний аяны тайлан 2011-2017 он
/Эх сурвалж: ХСҮТ-ийн тандалт, судалгааны нэгж/

	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	Бодит тоо	Хувиар
	(21 аймаг, 9 дүүрэг)	(12 аймаг, 8 дүүрэг)	(8 аймаг)	(9 аймаг)	(12 аймаг)	(8 аймаг)	(4 аймаг, 1 дүүрэг)		
Эрүүл	3684	5455	4459	3344	6256	5577	2216	30991	26.8
Хавдрын урьдал	1591	1891	641	607	2177	1096	913	8916	7.7
Хоргүй хавдар	1906	1615	914	1176	1625	897	496	8629	7.5
Хортой хавдар гэж сэжиглэж буй	254	174	84	200	194	191	134	1231	1.1
Хортой хавдар	110	104	36	71	80	100	49	550	0.5
Хяналтын үзлэг	2128	1096	1128	1694	1821	1411	559	9837	8.5
Бусад өвчлөл	10841	10096	6271	6981	10578	7547	3257	55571	48.0
Хийгдсэн эс, эдийн шинжилгээ	2061	2273	1228	1065	1534	1390	984	10535	
Бүгд үзлэг	20514	20431	13533	14073	27731	16819	7624	115725	
Хийгдсэн мэс ажилбар	100	65	78	76	84	51	23	477	